

"Ашигт малтмалын тухай" хуулийн 9.1.10, 42.1- т зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулна. Энэхүү гэрээ / цаашид Олон талт хамтын ажиллагааны гэрээ гэнэ/ нь ерөнхий загвартай.

Засгийн газрын 2016 оны 179 дүгээр
тогтоолын хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР
НЭМЭГДҮҮЛЭХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ОРУУЛАХ ТАЛААР ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ**

Энэхүү гэрээг нэг талаас Завхан аймгийн Завханмандал сумын захиргааг төлөөлөн Засаг дарга Т. Дэлгэрсайхан (цаашид "Засаг дарга" гэх), Нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Шувуун хар уул ХХК-ийг төлөөлөн Гүйцэтгэх захирал үүргийг орлон гүйцэтгэгч Н.Энхтайван (цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2019 оны 02 дугаар сарын 26 -ны өдөр байгуулав.

ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

- ❖ Уул уурхайн компани, засаг захиргааны байгууллага, иргэд хоорондын нийгмийн хариуцлагыг сайжруулах
- ❖ Хуулийн хэрэгжилтэд олон нийтийн албан ёсны хяналт, оролцоог бий болгох
- ❖ Уул уурхайн үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг дэмжих
- ❖ Сайн засаглалыг хөгжүүлэх, орон нутгийн хүн ам, нийгэм эдийн засгийн байдалд бодит дэмжлэг үзүүлэх
- ❖ Уул уурхайн үйлдвэрлэлээс үйлдэлтэй байгаль орчин, хүний эрхийн зөрчлийг бууруулах, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээ нь Монгол улсын Ашигт малтмалын тухай хууь болон холбогдох хууль тогтоомжийн дагуу олгосон талбайд Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбайд орших Мандал багийн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр, талуудтай тохиролцон дэмжлэг үзүүлнэ.

Хоёр. Засаг даргын эрх, үүрэг

2.1 Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1 Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах.

2.1.2 Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол үнэн зөв мэдээлэл өгч, саналыг нь авах.

2.1.3 Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс Тусгай эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх.

2.1.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах.

2.1.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих.

2.1.6 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шуурхай шийдвэрлэж, зохих хариуг өгөх.

2.1.7 Шаардлагатай тохиолдолд уурхайд цагдаагийн болон эмнэлэг, харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэх, дэмжиж хамтран ажиллах.

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1 Энэхүү гэрээний хүрээнд Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1 Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх.

3.1.2 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтанд хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай

хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах, энэ талаар МОНЗ-д мэдэгдэх

3.1.3 Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухай орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах талаар талуудтай хамтран ажиллах

3.1.4 Нийт ажлын байрны 40-өөс доошгүй хувьд буюу тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшиний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах.

3.1.5 Өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх

3.1.6 Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн багийн иргэд болон орон нутгийн иргэдэд тогтмол мэдээлэл өгч байх.

3.1.7 Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох.

3.1.8 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах.

3.1.9 Гамшигийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх.

3.1.10 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нутгийн иргэдэд тусгайлан олгосон зөвшөөрлийн дагуу түүх соёлын дурсгалт болон шүтлэгт газарт нэвтрэн орон, шашин соёлын зан үйлээ хэрэгжүүлэх боломж олгох.

3.1.11 Тусгай зөвшөөрлийн талбайд орших малчдын өвөлжөө хаваржаа малын бэлчээр, хадлангийн талбай, худаг, ундны эх үүсвэрт хохирол учруулахгүй байх.

3.1.12 Нутгийн иргэдийн аюулгүй байдлын үүднээс бэлчээр, усандаа хүрэн замыг хоосон бол иргэдтэй зөвлөлдөн өөр боломжит хувилбар, эх үүсвэрийг бий болгох үүрэгтэй.

Дөрөв. Гэрээний хэрэгжилт

4.1 Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичиг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногт байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөд хүргүүлнэ.

4.2 Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлнэ.

4.3 Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор дэд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 2019 онд нийт 5 000 000 / таван сая / төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

Харилцах данс:

Банкны нэр: Төрийн сангийн данс

4.5 Тусгай зөвшөөрөлд эзэмшигчийн санхүүжилтийг дараах чиглэлийн хүрээнд санхүүжүүлж, зохион байгуулж ажилласан байна.

1. Байгаль орчныг хамгаалах
2. Дүйцүүлэн хамгаалах чиглэл / БОМТ-д тусгасан газар/
3. Хог хаягдлыг дахин боловсруулах чиглэл
4. Өрхийн амжиргаа бага иргэдийг ажлын байртай болох чиглэл

Тав. Гэрээний хариуцлага

5.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

5.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаар мэдээллийг геологи уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

5.3 Гэрээний 1 талын гүйцэтгэхгүй байгаа үүргийг сайн дураараа гүйцэтгэсэн тал нь гарсан бүх зардлыг буруутай талаасаа шаардан авах эрхтэй.

5.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний 5.4, 5.5-дахь хэсэгт заасан хамтын ажиллагааны гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд алданги тооцох эсэхийг МОНЗ шийдвэрлэнэ. Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйл заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

6.1 Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

6.2 Компани өрөө хянан зохицуулах боломжгүй давагдашгүй хүчин зүйлс бий болсон тохиолдолд түүнийг арилгах хүртэл санд хийх төлбөрийг хойшлуулах эсэх талаар Хамтын ажиллагааны хорооны хурлаар оруулж шийдвэрлэж болно.

Долоо. Гэрээ хүчин төгөлдөр болох

7.1 Талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.2 Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.


7.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

7.4 Гэрээг монгол хэл дээр гурван хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ
ЗАВХАНМАНДАЛ СУМЫН

ЗАСАГ ДАРГА

 Т. ДЭЛГЭРСАЙХАН

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ
ШУВУУН ХАР УУЛ ХХК-ИЙ

 ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ОРЛОН ГҮЙЦЭТЭГЧ
Н. ЭНХТАЙВАН